

5. Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ

5.1 Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ

Хүн ам, өрх:


2010 оны жилийн эцсийн байдлаар аймгийн нийт хүн 82.2 мянга, өрх 20.3 мянгад хүрч, өнгөрсөн оноос хүн амын тоо 0.5 хувиар буурч, өрхийн тоо 0.4 хувиар өссөн дүн гарлаа. Нийт хүн амын 34.4 хувийг 0-15 насны хүүхэд, 60.5 хувийг 16-59 насны хүн ам буюу хөдөлмөрийн насны хүн ам, 5.1 хувийг 60 ба түүнээс дээш насны өндөр настан эзэлж байна.



Хөдөө аж ахуй:



2010 оны жилийн эцсийн байдлаар 8500 малчин өрх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж, 18043 малчид уг салбарт ажиллаж, 1639.1 мянган мал тоолуулсанаас тэмээ 16339, адуу 64646, үхэр 81018, хонь 594179, ямаа 882918 толгойг тус тус тоолуулж мал урьд оныхоос 27.7 хувиар буюу 629.3 мянган толгойгоор буурлаа.





Энэ нь аймгийн ихэнх сумдын нутгаар зуд болон зудархаг байсанаас мал хорогдож, мөн малчид малаа зах зээлд ихээр худалдан борлуулсан, зуншлага оройтож, гандуу байсан, бэлчээр царцаанд талхлагдсан зэрэг байгаль цаг уурын нөхцөлөөс хамаарч хорогдол гарахад нөлөөсөн байна.



Сумдад 2010 онд 67 худаг шинээр гаргасаны дотор инженерийн хийцтэй 27, энгийн худаг 40-ыг улсын болон гадаадын төсөл хөтөлбөр, малчид өөрсдийн хүчээр гаргаж 308.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн нь өмнөх онтой харьцуулахад шинээр гаргасан худгийн тоо 9-өөр нэмэгдэж

бэлчээрийг усжуулахад анхаарч ажиллаа. 2010 онд 44 худгийг засварлаж, нийт засварласан худгийн 82.5 хувийг гадаадын төсөл хөтөлбөрөөс санхүүжүүлж засварлалаа.


Үйлдвэрлэлийн салбарын борлуулалт буурсан шалтгаан нь Орос Монголын хамтарсан консервны үйлдвэр болох “РМПК” ХХК-ны борлуулалт өмнөх оны мөн үеийнхээс 3 дахин буурсантай холбоотой байна.



Дотоодын нийт бүтээгдэхүүн 94238.4 сая төгрөг болж, 2008 онтой харьцуулахад 18.1 хувь буюу 20879.5 сая төгрөгөөр буурч, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 1140.5 мянган төгрөг байна. Буурсан шалтгаан нь эдийн засгийн хямрал, аж ахуйн нэгж байгууллагууд үйл ажиллагаагаа бууруулсантай холбоотой байна.


Шуудан холбоо, интернэтийн үйлчилгээ:

Холбооны байгууллага нь байгууллага иргэдэд 1270 телефон цэг, 8 таксофон цэгээр үйлчилж, Mobicom, Skytel, Gmobile, Unitel, F-zone зэрэг үүрэн телефоны операторууд нийт 48956 үүрэн телефон хэрэглэгчтэй байна.



2010 онд интернет үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчдийн тоо 6580, интернэтийн байнгын хэрэглэгчдийн тоо 720, шуудан холбооны алба нь 56331,0 мян.төгрөгийн хэвлэл захиалагийн борлуулалт 9,4 мянган ширхэг бичиг захидал, илгээмж явуулж, 7,9 мянган ширхэг бичиг захидал, илгээмж хүлээн авч байгууллага, хөдөлмөрчдөд хүргэх үйлчилгээг үзүүллээ.

Тээвэр:



2010 онд тээврийн салбарт 151 хүн ажиллаж 94.2 сая төгрөгийн орлого оруулсан нь өнгөрсөн онтой харьцуулахад 9 хувь буюу 8.7 сая төгрөгөөр нэмэгдлээ. Тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд ачаа эргэлт 92047.1 мян.тн.км, зорчигч эргэлт 31315 хүн.км-ийн үйлчилгээ хийлээ.

Нийгмийн халамж, даатгал:

Аймгийн дүнгээр нийгмийн халамжийн сангаас 17.7 мянган хүнд 3362.9 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, нийгмийн даатгалаас 10904 хүнд 10306.4 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, хүний хөгжлийн сангаас 84960 хүнд 8174.4 сая төгрөгийг олгоод байна.

2010 оны жилийн эцсийн байдлаар Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэст ажилгүй 1320 хүн бүртгэгдсэнээс 768 нь эмэгтэйчүүд, 25 хувь нь дээд боловсролтой, 8 хувь нь тусгай дунд боловсролтой, 8 хувь нь мэргэжлийн анхан шатны, 65 хувь нь ерөнхий боловсролтой иргэд байна.

Нийгмийн халамж:

Д/д	Төрөл	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ (мян.төг)
1	Нийгмийн халамжийн тэтгэвэр	1853	974.643.570
2	Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж	3621	753.637.940
3	Нийгмийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх тусламж хөнгөлөлт	6255	558.547.000
4	Олон нийтийн оролцоонд түшигэлсэн халамжийн үйлчилгээ	132	25.427.000
5	Ахмад настанд үзүүлсэн тусламж хөнгөлөлт	4306	438.013.880
6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж хөнгөлөлт	884	110.485.810
7	Алдар цолтой ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт	50	104.935.600
8	Алдарт эхийн одон	5603	717.400.000
9	Жирмэсэн хөхүүл эхчүүдийн мөнгөн тэтгэмж	2401	506.624.760
10	Хүний хөгжлийн сангийн хишиг, хувь	85218	8.000.170.000
11	Дүн	110323	110323

Нийт түр болон бүр ажлын байранд 938 хүн орсны 20.1 хувь нь төрийн болон төсөвт байгууллага, 43.3 хувь нь нөхөрлөл, компанид 3.4 хувь нь хоршоонд, 33.1 хувь нь хувиараа болон зам, барилга, худалдаа, тээврийн салбаруудад ажиллаж байна.

Хяналт, шалгалт

Аймгийн Аудитын газар 2010 онд бүтээгдэхүүний 4 ангид нийт 270 бүтээгдэхүүн ажил үйлчилгээ нийлүүлэх үрдүнгийн гэрээ хийж, гэрээний дагуу 287 бүтээгдэхүүн ажил үйлчилгээ буюу 17 бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг нэмж нийлүүлэн, гэрээгээ 106.3 хувиар биелүүллээ. 2010 онд 133 байгууллагын 2009 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах аудит хийж, санхүүгийн тайлангийн аудитын дүнгээр 14 тэрбум 381.7 сая төгрөгийн алдаа илрүүлэн, илрүүлсэн алдааг цаг тухай бүр засуулж, 56 сум, байгууллага, төсөл хөтөлбөрийн нэгжид гүйцэтгэлийн аудит хийж гүйцэтгэлийн аудитаар хууль тогтоомж, эрх зүйн акт зөрчсэнтэй холбоотой 634.4 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлсэн байна. Гүйцэтгэлийн аудитаар 2 тэрбум 267.0 сая

төгрөгний үр өгөөжийг гүйцэтгэлийн аудит хийсэн сум, төсөвт байгууллагуудад бий болгон орон нутгийн төсвөөс авсан 1 төгрөгийн хариуд 22.5 төгрөгний үр өгөөж бий болгосон байна.

Мөн 2010 онд аймгийн Засаг даргын тамгын газрын 5 хэлтэс, 16 сум, 18 байгууллага, 50 гаруй багийн үйл ажиллагаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж зааварчилгаа зөвлөмж өгч ажиллаа.

Боловсрол Соёл, Эрүүл мэндийн салбар:

Сургуулийн өмнөх боловсролын байгууллага


Аймгийн хэмжээнд 2010-2011 оны хичээлийн жилд 27 цэцэрлэгт 5707 хүүхэд хамрагдаж байгаа нь 2008-2009 оны хичээлийн жилтэй харьцуулахад хүүхдийн тоо 1210 буюу 18.0 хувиар буурсан байна. Энэ нь хүн амын төрөлт багассантай холбоотойгоор цэцэрлэгт хамрагдах насны хүүхдийн тоо буурсан байна.



Сүүлийн 3 жилийн үзүүлэлтээс харахад сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт өсч, бүсийн дундажаас 5.5 хувиар, улсын дундажаас 6.4 хувиар дээгүүр үзүүлэлттэй байна. 2010-2011 оны хичээлийн жилийн эхэнд 27 цэцэрлэгт 150 үндсэн багш ажиллаж, нэг багшид ногдох хүүхдийн тоо 24.9 болж өмнөх оныхоос 0.7 хувиар өслөө.

Ерөнхий боловсролын сургууль:

2010-2011 оны хичээлийн жилийн эхэнд төрийн өмчийн ерөнхий боловсролын 23 сургууль сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа явуулж байгаагаас гүнзгийрүүлсэн сургалттай сургууль 1, гүнзгийрүүлсэн анги бүлэг хичээллүүлдэг сургууль 3 байна.




Суралцагчдын тоо 19592 болж, 2009-2010 оны хичээлийн жилийнхээс 817 суралцагч буюу 4 хувиар буурсан нь хүн амын тоо буурсан байдал, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суурь боловсрол эзэмшигчдээс нилээд их хэмжээгээр элсэх болсонтой холбоотой байна. Сүүлийн жилүүдэд суралцагчдын тоо улсын хэмжээнд буурч байгаа ба Ховд аймагт 2010-2011 оны хичээлийн жилийн эхэнд 817 сурагчаар буурсан нь улсын хэмжээний бууралтын хувиас 1.5 пунктээр доогуур үзүүлэлттэй гарлаа. Ерөнхий боловсролыг 12 жилийн сургалтанд шилжүүлэх ажил үргэлжилж, 1,2,3,7,8 дугаар ангиуд 12 жилийн хөтөлбөрөөр 7911 сурагч хичээллэж байгаагийн 59,7 хувь нь бага ангид 40,3 хувь суурь боловсролд хамрагдаж байна.

2010-2011 хичээлийн жилд нэгдүгээр ангид 1804 хүүхэд элсэн орсон нь 2009-2010 оны хичээлийн жилийнхээс 50 хүүхдээр буюу 2.7 хувиар буурч, нийт суралцагчдын 9.2 хувийг эзэлж байна. Дотуур байранд нийт 2295 сурагч амьдарч байгаагийн 1244 нь буюу 54.2 хувь нь эмэгтэй, 2262 буюу 98.5 хувь нь малчдын хүүхэд байна.

“Үдийн цай” хөтөлбөрт 2010 онд 1-5 дугаар ангийн нийт 9955 хүүхэд хамрагдаж байна.

Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын суралцагчид 1 бүлэгт 25 сурагч хамрагдаж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багш нар 944 байгаагийн 332 нь бага ангид, 414 нь дунд ангид, 198 нь ахлах ангид багшилж байна. Үндсэн багш нар нийт ажиллагчдын 58.3 хувийг эзэлж байна.



Аймгийн музей 4500 хүнд үйлчилсэнээс 2500 хүүхэд, 210 гадаадын үзэгч, 1790 бусад үзэгчидэд 3045 үзмэрээр үйлчилж шинээр 41 үзмэрийг нэмж 1500,0 мянган төгрөгийн орлогтой ажиллаа.

Номын сан 3900 байнгын уншигчиддаа 83,7 мянган ном, хэвлэл олгож үйлчиллээ.

Хөгжимт драмын театр 125 тоглолт, шинэ уран бүтээл 4-ийг туурвисныг 13500 үзэгч үзэж 16200,1 мянган төгрөгийн орлоготой ажиллаа.



Эрүүл мэндийн байгууллага 390,7 мянган хүнд үзлэг хийснээс урьдчилан сэргийлэх үзлэгт 95,9 мянган хүнийг хамруулж, 177,7 мянган хүн ор хоногоор үйлчилж, 2076 эх амаржуулж, 2075 хүүхэд эх барьж авлаа.

Нийт 410 хүн нас барсанаас 225 эрэгтэй, 185 эмэгтэй үүнээс 0-1 насны 12,2 хувь, 1-5 хүртэлх 2,9 хувийг хүүхдийн эндэгдэл эзэлж байна. Өнгөрсөн оны мөн

үетэй харьцуулахад амбульторын үзлэг 9,8 хувь, нас баралт 8 хувиар өссөн дүнтэй байна.

Барилга угсралт, их засвар:

Барилгын гүйцэтгэгч компаниуд 9926.9 сая төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэж, өнгөрсөн оны мөн үеэс 736.2 сая төгрөгөөр буюу 0.9 хувиар буурлаа.



Ховдын АЗЗА ХХК, Ховдын өргөө, Алтайн буйлааст, Ховдын тулга, Ховдын Хаш өргөө ХХК компаниуд 89.2 хувийг гүйцэтгэж ажиллаа. 50 ортой эхийн амаржих газар, 12 айлын орон сууц 2, хатуу хучилттай зам засвар зэрэг 38 гаруй объектод 5834.8 сая төгрөгийн барилга байгууламжуудыг барьж ашиглалтанд оруулжээ.

Төсөв санхүү:

Аймгийн төсөвт 3939,9 сая төгрөгийн орлого төвлөрч төлөвлөгөө 116,4 хувиар биелж, татварын орлого 8,6 хувиар, татварын бус орлого 8,4 хувиар тус тус төлөвлөгөө давуулан биелүүлжээ.

Орон нутгийн төсвөөс 5238,8 сая төгрөгийн санхүүжилт хийсний 4,4 хувийг нийгмийн даатгалын шимтгэл болон эрүүл мэндийн даатгалд, 39,9 хувийг цалин хөлсөнд, 46,0 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд, 3,5 хувийг татаас ба урсгал шилжүүлэгт, 6,2 хувийг хөрөнгийн зардалд зарцуулжээ.

Улсын төсвөөс 24820,5 сая төгрөгийн зарлага санхүүжилт хийсэн ба нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлд 5,6 хувийг, цалин хөлсөнд 54,0 хувийг, бараа үйлчилгээний бусад зардалд 32,3 хувийг, татаас ба урсгал шилжүүлэг болон бусад зардалд 8,1 хувийг зарцууллаа.

Гэмт хэрэг:

2010 онд аймгийн хэмжээнд 295 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 85 хэргээр буюу 22,4 хувиар буурсан. Гэмт хэргийг төрлөөр авч үзвэл хүнийг санаатай алах гэмт хэрэг нэг бүртгэгдсэн 80,0 буюу 4 хэргээр, хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 82 бүртгэгдсэн нь 5,7 хувь буюу 5 хэргээр, амиа хоролсон болон золгүй байдлаар нас барсан гэмт хэрэг 1 бүртгэгдсэн 93,7 хувь буюу 15 хэргээр, хүчиндэх хэрэг 7 бүртгэгдсэн нь 5 хэргээр 41,6 хувиар, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 85 бүртгэгдсэн нь 33,0 хувь буюу 42 хэргээр,

үүнээс иргэдийн өмчийг хулгайлах гэмт хэрэг 55 бүртгэгдсэн нь 46,6 хувь буюу 48 хэргээр, бусдын эд хөрөнгө залилан мэхлэх гэмт хэрэг 5 бүртгэгдсэн нь 28,5 хувь буюу 2 хэргээр, эд зүйл хууль бусаар хил нэвтрүүлэх хэрэг 1 бүртгэгдсэн нь 3 хэргээр буюу 75,0 хувиар, танхайрах гэмт хэрэг 24 бүртгэгдсэн нь 2 хэргээр буюу 7,6 хувиар, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг 4 бүртгэгдсэн нь 75,0 хувь буюу 12 хэргээр тус тус буурч, бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэрэг 2 бүртгэгдсэн нь 100 хувь буюу 1 хэргээр, ТХХАББАЖЭ гэмт хэрэг 36 бүртгэгдсэн нь 71,4 хувь буюу 15 хэргээр, мал хулгайлах гэмт хэрэг 22 бүртгэгдсэн нь 4,7 хувь буюу 1 хэргээр, албан тушаалын гэмт хэрэг 3 бүртгэгдсэн нь 3 дахин буюу 1 хэргээр тус тус өсчээ.

Өмнөх оны мөн үед гараагүй үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 1, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг 1 тус тус бүртгэгдсэн байна. Гэмт хэрэгт 379 хүн холбогдон шалгагдсан нь өмнөх мөн үеэс 4 хүнээр буюу 5,9 хувиар тус тус өссөн байна.



Согтуугаар үйлдсэн хэрэг 4,7 хувь буюу 5 хэргээр, хүүхэд оролцсон гэмт хэрэг 33,0 хувь буюу 4 хэргээр тус тус буурч, бүлэглэн үйлдэгдсэн хэрэг 2 буюу 5,4 хувиар тус тус өссөн байна. Гэмт хэргийн улмаас иргэд аж ахуйн нэгжид 223,2 сая төгрөгийн хохирол учирсанаас хэрэг бүртгэх мөрдөн байцаах ажиллагааны явцад 60,0 хувь буюу 149,0 сая төгрөгийн хохиролыг нөхөн төлүүлсэн байна.

Иргэд аж ахуйн нэгж албан байгууллагаас гэмт хэргийн тухай 972 гомдол мэдээлэл хүлээн авч шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 16,0 хувь буюу 180 өргөдлөөр буурсан байна. Шалгаж шийдвэрлэсэн гомдол мэдээллийн 64,6 хувь 5 хоногт 35,3 хувийг 5-19 хоногт шийдвэрлэсэн байна.

Үнэ, инфляци

2010 оны 12 сарын 21- ны байдлаар бараа үйлчилгээний үнэ тариф 2005 оны жилийн эцсийнхээс 86.2 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 26.4 хувиар өслөө. Хэрэглээний сагсанд авч судлагдаж буй 192 нэр төрлийн бараанаас үзэхэд 12 сард хүнсний бараа 96.1 хувь, хувцас бөс бараа 38.8 хувь, орон сууц, ус цахилгаан хийн бусад түлш 64.3 хувь, гэр ахуйн тавилга бараа 54.6 хувь, эм тариа эмнэлгийн үйлчилгээ 75.5 хувь, тээвэр 90 хувь, зочид буудал, нийтийн хоол дотуур байрны үйлчилгээ 103 хувь, бусад бараа үйлчилгээ 45 хувиар тус тус өссөн байгаа нь хэрэглээний бараа үйлчилгээний үнэ тарифын ерөнхий индексийг 86.2 хувиар өсөхөд нөлөөлсөн байна.

Харин холбоо, шуудангийн үйлчилгээ, боловсролын үйлчилгээ, амралт чөлөөт цаг, соёлын барааны үйлчилгээ үнэ өмнөх сарын хэмжээнд харьцангуй тогтвортой байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ